

  
МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 18 өдөр

Дугаар A/207

Хэрлэн сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн болон замын сангийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих Цэнхэрмандал суманд шугам сүлжээ, Хэрлэн суманд 4 дүгээр цэцэрлэгийн гаднах талбай, төв замаас орох хэсгийн замын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Э.Мөнх-Эрдэнэ Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: И.Баасанжав Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Г.Тамир “Хэнтий Ус” ХХК-ны ашиглалтын инженер

Х.Гоногр Иргэний төлөөлөл

Б.Цэрэнчимэд Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

